




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООЛЛОГЫН ДҮН



Улаанбаатар хот 2024 он




## 2023 оны мал тооллогын дүн 73 824

ААНБ- 3 699 (5.0%)

ӨРХ-70 125 (95.0%)



15 838  
(21.5%)



25 712  
(34.8%)



3  
(0.004%)



17 130  
(23.2%)



15 141  
(20.5%)



15 164



366



6 145



309 742

МОНГОЛ УЛСЫН  
МАСЛАХ, АЖАЙ-МАСЛАХ  
ЭРХЭМ ХӨДӨ АЖ АХуй

## ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн “в”, 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1316 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн А/866 тоот захирамжийн дагуу мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулах товын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтантай өрх, аж ахуй нэгж, байгууллагыг тоолох ажлыг зохион байгуулав.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2023 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

## ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх:** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

**Малчид:** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод, 6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

**Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:** 1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь, 1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

**Бог мал** - тухайн жилийн төл малаас бусад насны мал Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

**Төл мал:** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

**Малын тоо, толгойн өсөлт:** Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

**Бойжилтын хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45, Хуц, ухна - 25-30

**Малын зүй бус хорогдол:** Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

**Малын хэрэглээний зарлага:**

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоодод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжижирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно.

Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

**Малын хашааны хангамж:** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

**Тэжээл хангамж:** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг.

Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Хадлан өвс	0.45
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Гартэжээл, хужир шүү	1.0
Төмс ногооны хаягдал	0.22
Үр тарианы хаягдал	0.9
Лай	0.4
Сүрэл	0.25


**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.



## МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Малын тоо, бүтэц:** Сонгинохайрхан дүүрэгт 2023 оны мал тооллогоор нийт 73,824 толгой мал тоологдсон нь 2022 оноос 9,863(11.8%) толгой малаар буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2023 онд 427,182 толгой мал тоологдсон бөгөөд үүний 17.2 хувийг Сонгинохайрхан дүүргийн мал эзэлж байна..

Зураг 1. Дүүргийн нийт малын тоо, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад адуу 1912 толгойгоор (13.7%) өссөн бол тэмээ 20 толгойгоор (87.0%), үхэр 1052 толгойгоор (3.9%), хонь 3787 толгойгоор (18.1%), ямаа 6916 толгойгоор (31.4%) тус тус буурсан байна.

2023 онд нийт мал сүргийн 43.7 хувийг бог мал, 53.3 хувийг бод мал эзэлж байна.

Иргэдийн хувийн мал 70,125 толгой болж өмнөх оноос 9,766 толгойгоор, аж ахуйн нэгж, байгууллагын мал 3699 болж өмнөх оноос 97 толгойгоор малаар тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2019	2020	2021	2022	2023	Өсөлт, бууралт	
						Тоо	Хувь
Малын тоо, бүгд	70 768	80 712	82 358	83 687	73 824	-9 863	-11.8
Тэмээ	-	-	11	23	3	-20	-87.0
Адуу	7 493	10 492	13 125	13 926	15 838	1 912	13.7
Үхэр	24 514	24 357	24 248	26 764	25 712	-1 052	-3.9
Хонь	19 181	21 739	21 688	20 917	17 130	-3 787	-18.1
Ямаа	19 580	24 124	23 286	22 057	15 141	-6 916	-31.4
Хонин толгойд шилжүүлснээр*	236 338	263 037	280 063	298 949	295 910	25 602	-1.0

\* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

Хүснэгт 2. Малын тоо, хороогоор

Хороо	2022	2023	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт, хувь
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
21	71 633	63 056	3	12 773	22 771	14 998	12 511	-12.0
32	8 459	7 840	-	2 279	2 451	1 491	1 619	-7.3
33	2 813	2 129	-	518	331	380	900	-24.3
34	720	776	-	268	136	261	111	7.8
36	62	23	-	-	23	-	-	-62.9
<b>Дүн</b>	<b>83 687</b>	<b>73 824</b>	<b>3</b>	<b>15 838</b>	<b>25 712</b>	<b>17 130</b>	<b>15 141</b>	<b>-11.8</b>

2023 онд дүүргийн 21-р хорооны мал 12.0 хувиар, 32-р хороо 7.3 хувиар, 33-р хороо 24.3 хувиар, 36-р хороо 62.9 хувиар тус тус буурсан байна. Харин 34-р хороо 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Нийт малд эзлэх хувийн жин, малын төрлөөр

Нийт мал	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
	100	100	100	100	100
Тэмээ	0.0	0.0	0.0	0.0	0.0
Адуу	10.6	13.0	15.9	16.6	21.5
Үхэр	34.6	30.2	29.4	32.0	34.8
Хонь	27.1	26.9	26.3	25.0	23.2
Ямаа	27.7	29.9	28.3	26.4	20.5


Нийт мал сүргийн 0.004 хувийг тэмээ, 21.5 хувийг адуу, 34.8 хувийг үхэр, 23.2 хувийг хонь, 23.2 хувийг ямаа эзэлж байна. Малын нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад адуу, үхрийн эзлэх хувийн жин нэмэгдэж, хонь, ямааны эзлэх хувийн жин багассан байна.

**Малтай өрх, малчдын тоо:** 2023 оны мал тооллогоор нийт 73824 толгой мал тоологдсон нь 2022 оноос 9863(11.8%) толгой малаар буурсан байна. 2023 оны мал тооллогын дүнгээр малтай 1611 өрх, үүний дотор 970 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 54 өрхөөр нэмэгдэж, малчин өрхийн тоо 18 өрхөөр нэмэгдсэн байна.


Хүснэгт 4. Малтай өрх, малчдын насны бүлгээр

Он	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Түүний ам бүлийн тоо	Малчдын тоо	Насны бүлэг		
					15-34 насны	35-59 насны	60-аас дээш насны
2019	487	852	2 975	1 085	195	655	235
2020	594	812	2 815	1 104	210	719	175
2021	642	853	3 037	1 104	203	765	136
2022	605	952	3 443	1 304	227	870	207
2023	641	970	3 491	1 314	250	926	138

Зураг 2. Малчдын тоо, хүйсээр, оноор



Зураг 3 . Малчдын тоо, насны бүлгээр



Малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны 250(19.0%), 35-5 насны 926(70.5%), 60-аас дээш насны 138(10.5%) насны хүмүүс байна. Нийт малчдын 460 буюу 35.0 хувь нь эмэгтэй малчид байна Малчдыг насны бүлгээр авч үзвэл 15-34 насны

250(19.0%), 35-59 насны 926(70.5%), 60-аас дээш насны 138(10.5%) насны хүмүүс байна. Нийт малчдын 460 буюу 35.0 хувь нь эмэгтэй малчид байна.

**Мал төллөлт, төл бойжилт:** 2023 онд 33284 төл гарсны 28442 төл (85.4%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 10044 толгойгоор (26.1%) буурсан байна. Бойжуулсан нийт төлийн 3493 (12.3%) унага, 12493 (43.9%) тугал, 6544 (23.0%) хурга, 5909 (20.8%) ишиг тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

Малын төрөл	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн
Ботго	3	-	3	-		3	
Унага	4 077	584	3 493	178	53	1 176	57
Тугал	13 666	1 173	12 493	412	14	6 287	185
Хурга	7 842	1 298	6 544	830	14	2 530	51
Ишиг	7 696	1 787	5 909	323	5	3 488	126
Бүгд	33 284	4 842	28 442	1 743	86	13 484	419



**Малын хэрэглээний орлого зарлага:** 2023 онд оны эхний нийт малын 5925 (7.1%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 1903 (32.1%) хонь, 1794(30.3%) ямаа, үлдсэн 2228 (36.6%) бод малыг тус тус хүнсэнд зарцуулсан байна. Хүснэгт 10. Малын хэрэглээний орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Орлого			Хасагдсан				
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Шилжүүлсэн	Алдсан, улгайлагдса нолдохгүй байгаа	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Тэмээ	3	-	-	-	-	23	-	-
Адуу	3 599	744	2 491	317	60	3 325	394	826
Үхэр	3 595	231	6 447	701	66	7 347	1 834	1 388
Хонь	3 080	430	4 805	222	87	8 424	1 903	1 541
Ямаа	3 039	524	2 621	255	117	8 930	1 794	2 129
Дүн	13 316	1 929	16 364	1 495	330	28 049	5 925	5 884

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд тооллогоор худалдаж авсан 13316 толгой, бэлэн тоологдсон төл 16364 толгой, шилжиж ирсэн 1929 толгой мал байна. Харин шилжүүлсэн 1495 толгой мал, зүй бусаар 5884 толгой мал хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн 5925 толгой мал, 28049 толгой малыг зах зээлд борлуулсан нь зарлага талын үзүүлэлтийг бүрдүүлж байна.

**Малын хээл хаялт, сувайралт:** 2023 онд оны эхний хээлтэгч малын 18.3 хувьтай тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 5445 эх мал сувайрсан, 2241 эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 1013 толгойгоор, хээл хаясан мал 1547 толгойгоор өссөн байна.

Хүснэгт 11. Төллөх малын тооны өөрчлөлт мэдээлэл

Малын төрөл	Оны эхний хээлтэгч	Доод наснаас төллөсөн	Нэмэгдсэн	Хасагдсан	Хээл хаясан	Сувайрсан	Төллөсөн
Ингэ	15	-	-	12	-	-	3
Гүү	5 354	31	1 308	729	585	1 302	4 077
Үнээ	15 048	45	1 578	1 497	280	1 228	13 666
Эм хонь	10 644	40	1 279	2 353	607	1 162	7 841
Эм ямаа	11 026	60	1 249	2 132	769	1 753	7 681
Бүгд	42 087	176	5 414	6 723	2 241	5 445	33 268

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Дүүргийн нийт мал сүргийн 38856 (52.6%) нь хээлтэгч мал, 1235 (1.7%) нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 72 эм хонь, 77 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

Хүснэгт 13. Хээлтүүлэгч малын тоо

Төрөл	2019	2020	2021	2022	2023	Өсөлт, бууралт /тоо/
Буур	-	-	-	1	-	-1
Азарга	316	423	557	607	736	129
Бух	194	214	238	269	260	-9
Хуц	118	253	161	229	128	-101
Ухна	115	142	40	138	111	-27
<b>Бүгд</b>	<b>743</b>	<b>1 032</b>	<b>1 096</b>	<b>1 244</b>	<b>1 235</b>	<b>-9</b>


**Хээлтэгч мал:** 2023 оны мал тооллогоор 38856 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 3231 толгой (7.7%) малаар буурсан байна.

Хүснэгт 14. Хээлтэгч мал, төрлөөр

Төрөл	2019	2020	2021	2022	2023	Өсөлт, бууралт	
						тоо	хувь
Ингэ	-	-	4	15	-	-15	-100.0
Гүү	2 880	3 968	5 337	5 354	6 364	1 010	18.9
Үнээ	14 043	13 230	13 659	15 048	14 845	-203	-1.3
Эм хонь	9 732	11 271	11 376	10 644	9 110	-1 534	-14.4
Эм ямаа	8 940	13 034	12 460	11 026	8 537	-2 489	-22.6
<b>Бүгд</b>	<b>35 595</b>	<b>41 503</b>	<b>42 836</b>	<b>42 087</b>	<b>38 856</b>	<b>-3 231</b>	<b>-7.7</b>

Зураг 4. Хээлтэгч малын тоо

2023 онд дүүргийн нийт малын 38856 (52.6%) хээлтэгч мал эзэлж байна. Нийт хээлтэгч малын 6364 (16.4) гүү, 14845 (38.2%) үнээ, 9110 (23.4%) эм хонь, 8537 (22.0%) эм ямаа тус тус мал эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Гүү 1010 (18.9%) өссөн бол үнээ 203 (1.3%), эм хонь 1534 (14.4%), эм ямаа 2489 (22.6%) тус тус буурсан үзүүлэлтэй байна.



**Бэлтгэсэн хадлан тэжээл:** Дүүргийн хэмжээнд 2023 онд 18300.6 тонн хадлан, гар тэжээл 706.3 тонн, хужир шүү 416.3 тонныг тус тус бэлтгэсэн байна. 2022 онтой харьцуулахад хадлан 1818.8 тонн (11.0%) өссөн бол хужир шүү 12.5 тонн (2.9%), гар тэжээл 484.4 тонн (40.7%) тус тус буурсан байна.

Хүснэгт 15. Бэлтгэсэн хадлан тэжээл, тн

Хороо	Бэлтгэсэн хадлан	өөрсдийн бэлтгэсэн	Таримал тэжээл	Бэлтгэсэн дарш	Гар тэжээл	Хужир шүү	Төмс, хүнсний ногооны хаягдал	Үр тарианы хаягдал	Сүрэл
32	693.2	20	6.5	18	84	30	76	42.2	2
33	50.7	9.6	13.5	2.3	0.8	6.5	2	3.4	
34	25.8	13	15	-	1	-	-	2	
21	17 514.8	8 578.9	3 403.4	187	618.9	379.8	254	805.7	2
Бусад	16.1	3	8.0	1	1.5	-	26.4	41.2	1
Нийт	18 300.6	8 624.5	3 446.4	208.3	706.3	416.3	358.4	894.5	5

Зураг 2. Бэлтгэсэн хадлан тэжээл / тн/



**Тэжээвэр амьтад:** Мал, тэжээвэр амьтдын 2023 оны тооллогоор 6145 гахай, туулай 202, 310071 шувуу, үүнээс 309742 тахиа, цацагт хяруул 34, галуу 58, бөднө 237, зөгийн 12 бүл тус тус тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад гахай 1373 (28.8%), шувуу болон тахианы тоо 124591 (67.2%) тус тус өссөн байна.

Хүснэгт 16. Тэжээвэр амьтдын тоо

Төрөл	Бүгд	Үүнээс:							
		Хээлтэгч		Хээлтүүлэгч		Төл		Бусад	
		Оны эхний	Бэлэн тоологдсон хээлтэгч	Оны эхний	Бэлэн тоологдсон хээлтүүлэгч	Оны эхний	Бэлэн тоологдсон төл	Оны эхний	Бэлэн тоологдсон
Гахай	6145	669	726	50	57	2001	2823	1251	2539
Шувуу	310071	2382	189007	400	213	34	78262	-	42589
Тахиа	309742	1030	188759	176	132	31	78262	-	42589
Галуу	58	26	46	17	12	3	-	-	-
Цацагт хяруул	34	18	28	6	6	-	-	-	-
Бөднө	237	1308	174	201	63	-	-	-	-
Туулай	202	149	113	53	29	76	60	-	-
Зөгийн бүл	12	11	12	-	-	-	-	-	-
Бусад	129	81	45	64	57	27	27	-	-

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2023 онд 851.5 тонн гахайн мах, 75 сая ширхэг өндөг нийт 35.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

*Гэрийн тэжээвэр муур, нохой:* 2023 оны байдлаар гэрийн тэжээвэр 15164 нохой, 366 муур байна. Өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 3385 (18.2%) буурсан бол муурны тоо 102 (38.6%) өссөн байна.

Хүснэгт 17. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

Хороо	Нохойны тоо		Муурны тоо	
	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	764	713	41	57
2	1 601	784	-	-
3	493	604	1	5
4	570	431	-	-
5	492	382	5	5
6	156	217	4	2
7	519	482	4	8
8	488	379	13	7
9	344	412	1	4
10	587	636	9	22
11	518	584	5	21
12	10	27	3	4
13	12	16	-	2
14	19	23	8	5
15	30	27	10	6
16	14	17	-	6
17	24	31	4	4
18	48	12	4	2
9	13	13	2	2
20	36	72	4	8
21	999	624	64	47
22	923	254	0	-
23	331	275	0	-
24	1 249	1 148	1	5
25	278	231	7	4
26	381	235	9	13
27	20	31	3	5
28	263	251	14	12
29	6	8	3	2
30	212	241	0	-
31	367	395	1	2
32	519	185	0	14
33	2 497	2 321	0	14
34	616	478	3	5
35	330	399	12	16
36	427	236	7	14
37	4	32	2	5
38	15	26	5	4
39	446	388	3	-
40	444	504	5	11
41	531	312	6	4
42	581	435	1	14
43	372	293	-	5
<b>Нийт</b>	<b>18 549</b>	<b>15 164</b>	<b>264</b>	<b>366</b>